

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
4.1 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3. Менежментийн захидал .....	11
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.4 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
4.5 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.6 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР  
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ү.ТӨМӨРХУЯГ  
ТАНАА

2020.03.13 № 06/829  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, санхүүгийн программ хангамжид сайжруулалт хийлгэх, гадаад валютын хэрэгжсэн ашиг, алдагдлын тооцооллыг тайланд бүрэн тусгаагүй талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 21-ээс 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, "Гроут финанс Аудит" ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/234 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК “Эх орны хөгжлийн баталгаа, Эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК нь 1983 онд байгуулагдсан бөгөөд “Эрчим хүчний тухай” хууль, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу тус компанид Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2004 оны 49 дүгээр тогтоолоор цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, 2006 оны 106 дугаар тогтоолоор цахилгаан үйлдвэрлэх, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлүүдийг олгосон. Компани нь эдгээр тусгай зөвшөөрлийн дагуу цахилгаан, дулааныг үйлдвэрлэж, түгээх үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх
- Цахилгаан, дулааны эрчим хүчийг түгээх
- Цахилгаан, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах
- Цахилгаан, дулааны эрчим хүчийг худалдах үйл ажиллагаа байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй, 2018 оноос хойш өөрчлөгдсөн СТОУС-ын өөрчлөлт, шинэчлэлтийг нэмж тусгах шаардлагатай байна.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд OPENERP программ хангамж ашигладаг байна.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.5 хувиар тогтоов.

Тус компанийн үйл ажиллагаа тогтвортой, борлуулалтын орлогын дүн хэлбэлзэл багатай харьцангуй хэвийн гэж үзсэн тул нийт орлогыг материаллаг байдлын түвшнийг тогтоох суурь үзүүлэлт болгон сонголоо.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 195,438.8 сая төгрөгөөс тооцон 977.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 1,399.5 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс 279,911.5 сая төгрөгөөс тооцсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 264,890.7 сая төгрөгөөр буюу 28% хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж төлсөн зардал, тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны нэр	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,701.2</b>	<b>40,220.3</b>	<b>9,519.1</b>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	455.4	592.5	137.1
АВЛАГА	11,117.2	18,624.5	7,507.3
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО	3,564.0	2,121.4	(1,442.6)
БАРАА МАТЕРИАЛ	15,564.5	18,881.9	3,317.3
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>638,230.0</b>	<b>893,601.7</b>	<b>255,371.6</b>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	638,230.0	893,601.7	255,371.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>668,931.2</b>	<b>933,821.9</b>	<b>264,890.7</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>297,989.7</b>	<b>460,385.7</b>	<b>162,396.0</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,317.3	52,880.8	16,563.5
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	261,672.4	407,504.9	145,832.5
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>370,941.5</b>	<b>473,436.2</b>	<b>102,494.7</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>668,931.2</b>	<b>933,821.9</b>	<b>264,890.7</b>

Авлагын дансны үлдэгдэл өссөн нь Диспетчерийн үндэсний төв ХХК-с авах авлага 18,587.7 сая төгрөгт хүрч 7,364.5 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Авлагын дансны үлдэгдэлд 3-аас дээш жил болсон 288.2 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Үүнээс шүүхийн шатанд маргаантай байгаа, төлөгдөх эсэх нь тодорхойгүй эрсдэлтэй 219.1 сая төгрөгийн авлага байна. Компани нь авлагын насжилтаас шалтгаалан 5-100 хувиар найдваргүй авлагын нөөц байгуулдаг бөгөөд тайлант хугацааны эцэст 1,763.3 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь мазутын үлдэгдэл 142.2 сая, нүүрс 831.4 сая, үндсэн сэлбэг материал 2,285.0 сая, шатахуун тосолгооны материал 35.0 сая, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 33.3 сая, хангамжийн материал 35.0 сая төгрөгөөр тус тус



өссөнтэй холбоотой. Бараа материалын дансны үлдэгдэлд 3-аас дээш жил болсон 3,507.6 сая төгрөгийн 89,471 тоо хэмжээтэй бараа материал байна. Тайлант хугацаант 5-аас дээш жил болсон 1,533.2 сая төгрөгийн бараа материалд үнэлгээ хийлгэсэн бөгөөд үнэлгээний үр дүнд 374.1 сая төгрөгийн үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Түлш, эрчим хүчний сайдын 2007 оны 53 дугаар тушаалаар баталсан нүүрс, мазутны аюулгүйн нөөцийн хэмжээний дагуу материалыг бэлтгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 317,805.4 сая төгрөгөөр өссөн нь тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний нэмэгдэл болон Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын 2019 оны 09 сарын 23-ны дүгнэлтийг үндэслэн Үр ашгийг дээшлүүлэх төслийн 2 дугаар багц болох Зуух №1-8 -д үлээлгийн төхөөрөмж, Зуух №5-8 -ын тээрмийн бул тавгийн шинэчлэл 43,336.4 сая төгрөгийг хөрөнгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь Сангийн яамны "Зуух 1-8 үнс үлээлгэ, 5-8-ын бул тавагны шинэчлэлийн төсөл" болон Хөгжлийн банкны "ТА 1-4 шинэчлэх ЗГ-ДЦС-3 2018-19 төсөл"-ийн зээлүүдийг урт болон богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн нь шалтгаалжээ.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК нь тайлант хугацааны эцэст нийт 11 төрлийн 287,962.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнд Хөгжлийн банкнаас Турбоагрегат 1-4 шинэчлэлд зориулж авсан 177,095.5 сая төгрөгийн үндсэн зээл болон 1,154.4 сая төгрөгийн хүүгийн өглөг, Сангийн яамнаас эрчим хүчний үр ашиг дээшлүүлэх төсөл, зуухны шинэчлэлтийн төслийн 105,464.2 сая төгрөгийн үндсэн зээл болон 1,795.3 сая төгрөгийн хүүгийн өглөг дийлэнх хувийг эзэлж байна.

Төрийн өмч дансны үлдэгдэл 473,436.2 сая төгрөг болж 102,494.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны ашиг 1,563.7 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 111,055.0 сая төгрөгийн өсөлт, ажилчдын тэтгэвэр тэтгэмжийн нөөц дансны залруулга хийсэн 10,123.9 сая төгрөгийн бууралт нөлөөлжээ.

## **2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Эрчим хүчний сайдын 2019 оны 1 дүгээр сарын 8-ны 16 тоот тушаалаар Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн зорилтот түвшнийг тайлант онд 272,073.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 286,345.9 сая төгрөгийн орлого тайлагнаж, 14,272.1 сая төгрөгөөр давсан байна.

Борлуулалтын орлого 7,705.2 сая төгрөгөөр давсан нь цахилгааны эрчим хүчний орлого 14,272.1 сая төгрөгөөр, дулааны эрчим хүчний орлого 1,368.0 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна. Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 6-р сарын 13-ны 287 тогтоолоор цахилгааны тарифыг нэмсэнтэй холбоотой.

Тайлант хугацаанд нийт зардлыг 271,793.7 сая төгрөгөөр буюу өмнөх оныхоос 18,059.4 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 280,750.9 сая төгрөг зарцуулсан байна. Зардлын өсөлтөд түлшний зардал 3,766.2 сая төгрөг, үйл ажиллагааны бусад зардал 10,089.4 сая төгрөг, цахилгааны зардал 1,257.5 сая төгрөг, элэгдлийн зардал 754.7 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн, төлөвлөгөөнд тусгаагүй найдваргүй авлагын зардал 784.3 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөр 125.5 сая төгрөгийн зардлууд гарсан нь нөлөөлсөн байна.

Зорилтот түвшинд тайлант хугацаанд 250.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж 30.0 сая төгрөгийн орлогын албан татвар төлөхөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,563.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 4,031.3 сая төгрөгийн орлогын албан татвар төлөхөөр тайлагнасан байна.



## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 30 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 8,131.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 7,206.0 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 858.3 сая төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 66.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгав. Үүнд:

- Шинэчлэгдсэн хөдөлмөр хөлсний доод хэмжээг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэхээр тогтоосон байхад ажилчдын тэтгэвэр тэтгэмжийн нөөц ба өр төлбөрийн тооцоололд ашигласнаас Ажилчдын тэтгэвэр тэтгэмжийн нөөц ба өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд 2,496.7 сая төгрөгөөр илүү, хуримтлагдсан ашиг (алдагдлыг) уг дүнгээр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "Үнэн зөв байх" хуулийн заалт болон Үнэн зөв, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- МОН-Р 10 төслийн багц-2-ын хүрээнд ашиглалтад хүлээн авсан тоног төхөөрөмжийн өртөгт 816.7 сая төгрөгийн, ТА-4 төслийн хүрээнд ашиглалтад хүлээн авсан тоног төхөөрөмжийн өртөгт 396.7 сая төгрөгийн зээлийн хүүгийн төлбөрийг тус тус капиталжуулан бүртгэсэн нь НББОУС 23 "Зээлийн өртөг" стандарттай нийцээгүй;
- Тус компани нь барилга, байгууламжаас бусад бүх үндсэн хөрөнгөнд 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дахин үнэлгээ хийлгэн бүртгэж тайлагнасан. Дахин үнэлэгдсэн хөрөнгөөс түүвэрлэн шинэчлэн тогтоосон дүнг нягтлан шалгахад мазут аж ахуй, контейнер болон зарим тавилга, эд хогшил зэрэг хөрөнгүүдийн тогтоосон үнэ тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг илэрхийлж чадахгүй 2,350.9 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь СТОУС 13 "Бодит үнэ цэний хэмжилт"-тэй нийцээгүй;
- Тус компанид 183.4 сая төгрөгийн бараа материалын эдийн засгийн эрсдэл, өгөөж нь шилжин ирсэн хэдий ч хүлээн зөвшөөрч бүртгээгүй, урьдчилгаа төлбөрийг уг дүнгээр илүү илэрхийлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "Үнэн зөв байх" хуулийн заалт иж бүрэн, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй;
- Хөрөнгийн шалгуур хангасан 5.3 сая төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслийг тайлант жилийн борлуулалтын өртгийн дансанд бүртгэсэн байгаа нь СТОУС "Үзэл баримтлал"-ын 4.8 дугаар заалттай нийцээгүй;
- Бараа материалын дансанд 31.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцээгүй;
- Оршин суугч бус иргэний НӨАТ-ын өглөгийг 342.7 сая төгрөгөөр илүү бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг хангаагүй;
- ААНОАТ-ын тухай хууль болон аудитын залруулгын нөлөөллийг тусган орлогын албан татварын тооцооллыг хийж компанийн бүртгэсэн татварын зардалтай тулган шалгаж, 582.6 сая төгрөгөөр орлогын албан татварын зардал, өглөгийг илүү бүртгэсэн алдаануудыг залруулав.

2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй их засварын зардлаас 226.8 сая, урсгал засварын зардлаас 48.3 сая, бараа материалын худалдан авалтын зардлын төсвөөс 2.6 сая нийт 277.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Мөн Турбоагрегат №4 -ийн их засварын ажилд 570.0 сая төгрөгийн материал төлөвлөснөөс 717.7 сая төгрөгийн материал, 432.9 сая төгрөгийн ажлын хөлсний гүйцэтгэл гарч төлөвлөсөн дүнгээс 580.6 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д "Төрийн байгууллагаас бусад

төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

3. Компанийн удирдах албан тушаалтны хэрэгцээнд ашиглагддаг суудлын автомашины шатахууны зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг шалган үзэхэд Ландкрузер 200 маркийн суудлын автомашины шатахууны зарцуулалт 366.4 литр буюу 0.7 сая төгрөгийн хэтрэлттэй байгаа нь Засгийн газрын 184 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоосон.

Аудитаар илэрсэн 66.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК нь барилга байгууламжаас бусад бүх үндсэн хөрөнгөнд санхүүгийн тайлагналын зорилгоор, 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж, дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгаснаар, тус компанийн нийт хөрөнгө 111,899.8 сая төгрөгөөр нэмэгдсэн. Энэхүү дүн нь тайлант оны санхүүгийн байдлын тайланд материаллаг нөлөөлөлтэй бөгөөд аудитын хүрээнд дахин үнэлгээний тайлан, тооцоолол, үнэлгээний арга зүйг нягтлан шалган хөрөнгийн дахин үнэлгээний дүнд 2,350.9 сая төгрөгийн залруулгыг гүйцэтгэсэн. Гэхдээ аудитын цар хүрээнд хөрөнгийн дахин үнэлгээний дүн, тооцооллыг нягтлан шалгах ажил нь бүрэн хамрагдаагүй бөгөөд үнэлгээний дүн, тооцооллыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-с нягтлан шалгах шаардлага үүсч болзошгүй бөгөөд энэхүү нягтлан шалгалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн үр ашгийг дээшлүүлэх Мон Р-10 төслийн төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Эрчим хүчний яам, төслийн хэрэгжих хугацаа 2014-2018 он, төслийн зорилго нь “Эрчим хүч, дулаан үйлдвэрлэхэд шаардагдах нүүрс, дизель түлшний хэмжээг тодорхой түвшинд хэмнэх нөхцөлийг бүрдүүлэх, мөн Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн үндсэн тоноглолууд болох уурын турбин ба зуухны техникийн найдвартай ажиллагааг хангаснаар тус станцын дулааны болон эрчим хүчний үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, тулгамдаж буй эрчим хүчний дутагдлыг багасгах, иргэд болон аж ахуйн нэгжүүдийг тогтвортой, найдвартай эрчим хүчээр хангахад чухал хувь нэмэр оруулах юм. Энэхүү төслийн бүрэлдэхүүн багц 1-ийн хүрээнд Турба агрегат № 1-6 хяналт удирдлагын систем, ПЭН №1-4 хяналт удирдлагыг бүрэн шинэчлэн 2016 оноос эхлэн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар төслийн 1-р багцыг бүрэн дуусгаагүй, улсын комисс хүлээн аваагүй зэрэг шалтгаанаар хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй, хөрөнгөтэй холбоотой хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зардлыг мөн хүлээн зөвшөөрч бүртгээгүй байгаа бөгөөд энэхүү төсөлтэй холбоотой зээл, зээлийн хүүгийн төлбөр болон хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

2019 оны батлагдсан үнэ тарифын тооцоонд цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй байхаар тооцсон ч Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээрийг үндэслэн цалин хөлсийг 2019 оны 8 дугаар сараас нэмэгдүүлэн тодотгосон төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн байна. Бидний

ажиглалтаар Эрчим хүчний зохицуулах хороонд төлөгддөг зохицуулах үйлчилгээний хөлсний өсөлт эрчим хүчний үнэ тарифын өсөлтөөс илүү байна. Тухайлбал эрчим хүний тариф 2019 онд дунджаар өмнөх оноос 2 хувиар өссөн байхад зохицуулах үйлчилгээний хөлс 10 хувиар өссөн байгаа нь анхаарал татахуйц асуудал байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 464 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосноос 100 хувь барагдуулсан, 4,210.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлснээс 4,017.0 сая төгрөгийн 5 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. Их засвар, бараа материалын зардлын төсвөөс хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 193.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжээлээгүй тайлант онд энэ зөрчил давтагдсан байна.

Нийт 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 925.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 1,399.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. **НБББББ-тэй холбоотой асуудал**

3.1.1. Илрүүлэлт: Тус компани нь НБББББ-ийг 2017 онд шинэчлэн боловсруулсан бөгөөд гүйцэтгэх захирлын 2019 оны А71 дүгээр "НБББББ-ийг батлах" тушаал гарсан боловч 2019 онд бүртгэлийн бодлогыг нягтлан бодох бүртгэлдээ бүрэн мөрдөөгүй байна. Мөн 2018-2019 онд гарсан СТОУС-ын өөрчлөлтийг НБББББ-д тусгаагүй байна.

3.1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэл алдаатай, СТОУС-аас зөрүүтэй илэрхийлэгдэх

3.1.2 Өгсөн зөвлөмж: Батлагдсан НБББББ-ийг бүрэн мөрдөж ажиллах, СТОУС-ын шинэчлэл, өөрчлөлтийг НБББББ-д цаг тухай бүрт тусгаж байх.

3.1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Компанийн нягтлан бодох бүртгэлд мөрдөж байгаа НБББББ-т 2018-2020 онд шинэчлэгдсэн СТОУС-ын өөрчлөлтийг тусган боловсруулж батлуулан хэрэгжүүлнэ.

#### 3.2 **Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал**

3.2.1 Илрүүлэлт: Компанийн ашиглаж байгаа санхүүгийн программд шинэчлэл, тохируулга хийх шаардлагатай байна. Тухайлбал, тухайн дансны гүйлгээг хэвлэж харахад харьцсан данс нь зөв харагдаж байгаач ерөнхий дэвтрээс тухайн ажил гүйлгээг сонгон харахад харьцсан данс зөрүүтэй харагдах тохиолдол үүсэж байна. Энэ программ хангамж нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.11-ийн "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх" тухай заалт болон Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын дагуу зөвшөөрөгдсөн программын жагсаалтад ороогүй байна.

- 3.2.2 Эрсдэл: Санхүүгийн мэдээлэл алдаатай илэрхийлэгдэх
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн программ дээр зохих тохируулгыг хийх буюу “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ын дагуу санхүүгийн программ хангамждаа үнэлгээ хийлгэх.
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тус компанид ашиглагдаж буй OPENERP удирдлагын цогц программыг 2013 онд нэвтрүүлж ашиглаж байгаа ба санхүүгийн модулийг СТОУС, НББОУС-д нийцсэн программыг тохиргоог хийх, шинэчлэх нөхцөл үүсээд байна. Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ний өдрийн 47 тоот тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын дагуу зөвшөөрөгдсөн программыг нэвтрүүлэх ажлыг 2020 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна.

### **3.3 Зөрүүгийн тайланд тусгах гадаад валютын хэрэгжсэн ашиг, алдагдлын тухайд**

- 3.3.1 Илрүүлэлт: Гадаад валютаар үүссэн өглөг, авлагын төлөгдөх үед хэрэгжиж буй гадаад валютын хэрэгжсэн ашиг, алдагдлын тооцооллыг “Санхүү болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-д бүрэн тусгаагүй байна. Тухайлбал Хөгжлийн банкнаас 2015 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр ам.доллороор авсан зээлийн 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдөр төлөгдсөн 403,798.78 ам.долларын хэрэгжсэн алдагдлыг Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд дутуу тооцсоноос ААНОАТ-ын өглөг, зардлыг 66.7 сая төгрөгөөр илүү илэрхийлэхэд хүрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй, эрх үүрэг, иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй хангаагүй байна.
- 3.3.2 Эрсдэл: Гадаад валютын хэрэгжсэн ашиг, алдагдлын дутуу тооцсон дүн нь ААНОАТ-ын өглөг, зардалд нөлөөлөх эрсдэлтэй.
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: НББОУС 12 “Орлогын албан татвар” -ын дагуу татварын суурийг зөв тооцож, тайлант хугацаанд нөхсөн дүнгээр тохиргоо бичилт хийх, ААНОАТ-ын тооцооллыг хийж санхүүгийн тайланд тусгах, гадаад валютаар үүссэн өглөг, зээлийг төлөгдөх үед ханшийн зөрүүгийн хэрэгжсэн ашиг алдагдлын тооцооллыг харилцагч нэг бүрээр хийж байх.
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: “Санхүү болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-д Гадаад валютаар үүссэн өглөг, авлагын төлөгдөх үед хэрэгжиж буй гадаад валютын хэрэгжсэн ашиг, алдагдлын тооцооллыг хийж тайланд тусгаж бүртгэнэ. Дээрх тооцоололтой холбоотой татварын болон бүртгэлийн чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан сургалт зохион байгуулж нягтлан бодогчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.3 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	455,384,043.30	592,455,956.46
1.1.2	Дансны авлага	10,765,299,826.86	18,167,341,613.85
1.1.3	Бусад авлага	351,931,671.83	457,180,919.30
1.1.4	Бараа материал	15,564,522,480.90	19,034,265,111.29
1.1.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,564,026,868.94	1,938,029,854.16
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>30,701,164,891.83</b>	<b>40,189,273,455.06</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	537,391,271,802.63	671,580,266,080.11
1.2.2	Биет бус хөрөнгө	48,246,388,189.24	47,949,030,132.78
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	52,592,384,749.36	173,881,374,941.54
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>638,230,044,741.23</b>	<b>893,410,671,154.43</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>668,931,209,633.06</b>	<b>933,599,944,609.49</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	15,092,191,179.46	11,601,030,912.00
2.1.1.2	Цалингийн өглөг	3,585,605,617.00	3,997,099,172.00
2.1.1.3	Татварын өр	1,984,599,109.40	6,872,978,530.22
2.1.1.4	НДШ-ийн өглөг	34,065,845.78	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	9,612,742,502.61	18,778,297,253.26
2.1.1.6	Хүүний өглөг	422,021,265.25	3,158,960,647.33
2.1.1.7	Урьдчилж орсон орлого	5,055,749,524.19	5,112,746,557.18
2.1.1.8	Нөөц /өр төлбөр/	489,118,799.48	736,400,743.81
2.1.1.9	Бусад богино хугацаат өр төлбөр	41,233,031.05	1,677,134,942.62
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>36,317,326,874.22</b>	<b>51,934,648,758.42</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	128,320,705,665.34	269,184,405,979.69
2.1.2.2	Нөөц /өр төлбөр-урт/	2,652,290,347.31	7,253,117,956.77
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	10,487,200,858.09	12,568,608,574.24
2.1.2.4	Хойшлогдсон орлого	120,212,196,159.44	116,232,148,269.24
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>261,672,393,030.18</b>	<b>405,238,280,779.94</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>297,989,719,904.40</b>	<b>457,172,929,538.36</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	107,919,748,900.04	107,919,748,900.04
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	254,003,946,545.24	312,961,118,390.38
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	48,769,166,973.00	48,769,166,973.00
2.3.4	Хуримтлагдсан ашиг	(39,751,372,689.62)	6,776,980,807.71
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>370,941,489,728.66</b>	<b>476,427,015,071.13</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>668,931,209,633.06</b>	<b>933,599,944,609.49</b>

#### 4.4 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	245,528,384,735.28	271,407,878,141.64
2	Борлуулалтын өртөг	(241,006,110,887.92)	(261,201,362,463.59)
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>4,522,273,847.36</b>	<b>10,206,515,678.06</b>
4	Түрээсийн орлого	268,644,474.16	212,722,621.43
5	Хүүгийн орлого	150,323,485.76	85,141,638.36
6	Бусад орлого	7,732,025,434.93	8,205,806,034.96
7	Борлуулалт маркетингийн зардал	(1,449,197,956.45)	(2,221,945,758.74)
8	Ерөнхий ба удирдлагын зардал	(2,502,856,147.80)	(3,682,712,459.24)
9	Бусад зардал	(4,566,931,482.62)	(3,576,206,151.87)
10	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(4,209,222,740.71)	(4,555,164,941.51)
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(345,385,699.24)
<b>12</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(54,941,085.37)</b>	<b>4,328,770,962.21</b>
<b>13</b>	<b>Орлогын татварын зардал</b>	<b>(1,528,409,113.78)</b>	<b>(3,448,688,048.80)</b>
<b>14</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(1,583,350,199.15)</b>	<b>880,082,913.41</b>
<b>15</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>16</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(1,583,350,199.15)</b>	<b>880,082,913.41</b>



#### 4.5 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>235,790,858,558.58</b>	<b>254,126,527,275.32</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	233,246,140,455.27	251,956,769,210.56
1.1.2	Бусад мөнгөн орлого	2,544,718,103.31	2,169,758,064.76
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>204,727,591,575.02</b>	<b>214,623,974,700.35</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	34,462,784,041.75	36,720,396,461.42
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,035,000,000.00	11,860,740,274.29
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	101,568,000,000.00	109,000,293,945.00
1.2.4	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,585,412,188.82	25,720,435,620.07
1.2.5	Хүүгийн төлбөрт төлсөн		5,129,229,764.86
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	14,654,946,719.85	15,360,159,236.63
1.2.7	Бусад мөнгөн зарлага	10,421,448,624.60	10,832,719,398.08
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>31,063,266,983.56</b>	<b>39,502,552,574.97</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>159,187,122.13</b>	<b>85,141,638.36</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	8,863,636.37	-
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	150,323,485.76	85,141,638.36
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>77,036,326,041.33</b>	<b>148,173,594,715.99</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,429,191,866.32	35,248,743,282.18
2.2.2	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	48,607,134,175.01	112,924,851,433.81
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(76,877,138,919.20)</b>	<b>(148,088,453,077.63)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>48,887,426,212.35</b>	<b>128,011,922,320.89</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	48,887,426,212.35	128,011,922,320.89
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,147,480,751.78</b>	<b>19,288,949,905.07</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,012,909,221.78	19,288,949,905.07
3.2.2	Төлсөн ногдол ашиг	134,571,530.00	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>43,739,945,460.57</b>	<b>108,722,972,415.82</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(2,073,926,475.07)</b>	<b>137,071,913.16</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,529,310,518.37</b>	<b>455,384,043.30</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>455,384,043.30</b>	<b>592,455,956.46</b>

#### 4.6 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>107,919,748,900.04</b>	<b>135,387,610,315.27</b>	-	<b>(39,861,722,562.24)</b>	<b>203,445,636,653.07</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(245,584,928.24)	(245,584,928.23)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>107,919,748,900.04</b>	<b>135,387,610,315.27</b>	-	<b>(40,107,307,490.48)</b>	<b>203,200,051,724.84</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,583,350,199.15)	(1,583,350,199.15)
Өмчид гарсан өөрчлөлт		118,616,336,229.97		1,939,285,000.00	120,555,621,229.97
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			48,769,166,973.00		48,769,166,973.00
<b>2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>107,919,748,900.04</b>	<b>254,003,946,545.24</b>	<b>48,769,166,973.00</b>	<b>(39,751,372,689.62)</b>	<b>370,941,489,728.66</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(7,627,225,146.07)	(7,627,225,146.07)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>107,919,748,900.04</b>	<b>254,003,946,545.24</b>	<b>48,769,166,973.00</b>	<b>(47,378,597,835.69)</b>	<b>363,314,264,582.59</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				880,082,913.41	880,082,913.41
Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн өөрчлөлт		58,957,171,845.14		53,275,495,730.00	112,232,667,575.14
<b>2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>107,919,748,900.04</b>	<b>312,961,118,390.38</b>	<b>48,769,166,973.00</b>	<b>6,776,980,807.72</b>	<b>476,427,015,071.15</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: 2020.03.10	Аудитын нэр: Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/25/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК	сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Их засварын зардлын төсвөөс 226.8 сая төгрөг, урсгал засварын зардлаас 48.3 сая төгрөг, бараа материалын худалдан авалтын зардлаас 2.6 сая төгрөг нийт 277.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй ндсэн хөрөнгө худалдан авсан байна. Мөн Турбоагрегат №4-ийн их засварын ажилд 570.0 сая төгрөгийн материал төлөвлөж, 717.7 сая төгрөгийн материал, 432.9 сая төгрөгийн ажлын хөлсний гүйцэтгэл гарч төлөвлөсөн дүнгээс 580.6 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан.	858.3	Албан шаардлага	Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	Ж:Отгон Д.Төмөртогоо
2	Компанийн удирдах албан тушаалтны хэрэгцээнд ашиглагддаг суудлын автомашины шатахууны зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг шалган үзэхэд Ландкрузер 200 маркийн суудлын автомашины шатахууны зарцуулалт 366.4 литр буюу 0.7 сая төгрөгийн хэтрэлттэй байна.	0.7	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал	Ү.Төмөрхуяг
3	Тус компани нь НБББББ-ийг 2017 онд боловсруулсан бөгөөд гүйцэтгэх захирал 2019 оны А71 дүгээр "НБББББ-ийг батлах тушаал" гаргасан ч 2019 онд бүртгэлийн бодлогыг нягтлан бодох бүртгэлдээ бүрэн мөрдөөгүй байна. Мөн 2018-2019 онд гарсан СТОУС-ын өөрчлөлтийг НБББББ-д тусгаагүй байна.	-	Зөвлөмж	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	Д.Төмөртогоо
4	Компанийн ашиглаж байгаа санхүүгийн программ дээр тохируулга хийх шаардлагатай байна. Тухайлбал, тухайн дансны гүйлгээг хэвлэж харахад харьцсан данс нь зөв харагдаж байгаач ерөнхий дэвтрээс тухайн ажил гүйлгээг сонгон харахад харьцсан данс зөрүүтэй харагдах тохиолдол үүсэж байна. Мөн тус программ хангамж нь зөвшөөрөгдсөн программын жагсаалтад ороогүй байна.	-	Зөвлөмж	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	Д.Төмөртогоо

5	<p>Гадаад валютаар үүссэн өглөг, авлагын төлөгдөх үед хэрэгжиж буй гадаад валютын хэрэгжсэн ашиг, алдагдлын тооцооллыг “Санхүү болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-д бүрэн тусгаагүй байна. Тухайлбал Хөгжлийн банкнаас 2015 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр ам.доллаар авсан зээлийн 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдөр төлөгдсөн 403,798.78 ам.долларын хэрэгжсэн алдагдалыг Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд дутуу тооцсоноос ААНОАТ-ын өглөг, зардлыг 66.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан.</p>	66.7	Зөвлөмж	<p>Судалгаа хөгжлийн албаны дарга</p> <p>Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга</p>	<p>Г.Галбадрах</p> <p>Д.Төмөртоогоо</p>
	<b>Дүн</b>	<b>925.7</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/64

Улаанбаатар хот

С.А.Г - 2020/05/СТА-ТӨЧГ

Хэтрүүлэн зарцуулсан шатахууны  
зардлыг төлүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Компанийн удирдах албан тушаалтны хэрэгцээнд ашиглагддаг Ландкрузер 200 маркийн суудлын автомашины шатахууны зарцуулалтад 366.4 литр буюу 681,485.00 (Зургаан зуун наян нэгэн мянган дөрвөн зуун наян таван) төгрөг хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 184 дүгээр тогтоолын 2 дугаар заалт “Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоног (баярын болон долоо хоногийн амралтын өдрийг оролцуулан)-т дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см<sup>3</sup>-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хэрүүлэн зарцуулсан шатахууны зардал болох 681,485.00 (Зургаан зуун наян нэгэн мянган дөрвөн зуун наян таван) төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаас гаргуулж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;



Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie\_Kheree\Akt\2020\0319SAG1.Docx

001090163



2. Актын биелэлтийг 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт хариуцуулав.

## АКТЫГ

**ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  
 Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
 Ц.ХОСЖАРГАЛ  
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БЯМБА

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
 Ү.ТӨМӨРХУЯГ  
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
 Д.ТӨМӨРТООГОО

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.





**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/143

Улаанбаатар хот

СМГ- 2020/25/СТА - ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, их засварын зардлаас 226.8 сая төгрөг, урсгал засварын зардлаас 48.3 сая төгрөг, бараа материалын худалдан авалтаас 2.6 сая төгрөг нийт 277.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Мөн Турбоагрегат №4-ийн их засварын ажилд 570.0 сая төгрөгийн материал төлөвлөж, 717.7 сая төгрөгийн материал, 432.9 сая төгрөгийн ажлын хөлсний гүйцэтгэл гарч төлөвлөсөн дүнгээс 580.6 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д “Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдан авах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө худалдан авах, батлагдсан төлөвлөгөөг мөрдөх, төлөвлөгөөг үл үндэслэлтэй боловсруулах зэрэг нийт 858.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртогоо нарт хариуцуулав.

**ТОГТООСОН:**  
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
 АУДИТОР *Б. Наранчимэг*  
 Ц.НАРАНЧИМЭГ  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 Ц.ХОСЖАРГАЛ  
 ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
*Б.Бямба*  
 Б.БЯМБА

**АЛБАН ШААРДЛАГЫГ:**

**ЗӨВШӨӨРСӨН:**  
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
*Ү.Төмөрхуяг*  
 Ү.ТӨМӨРХУЯГ  
 САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
 ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ  
*Д.Төмөртогоо*  
 Д.ТӨМӨРТӨГӨО

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*





